

ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН НИЙГМИЙН БОДЛОГЫН МЭРГЭЖИЛТЭН
Д.ДАВГЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Бие лэлт ийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1. Зорилт 1. “ Нийгмийн салбарын талаарх хууль тогтоомж, бодлого, шийдвэр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг орон нутагт зохион байгуулах, арга зүйгээр хангах, тайлагнах							
1.	Арга хэмжээ 1 Салбарын хэмжээнд мөрдөгдөж байгаа Хүүхэд хамгааллын тухай хууль /шинэчилсэн найруулга/ талаар иргэдэд мэдээлэл түгээх	Сургалт мэдээлэлд хамрагдсан иргэдийн тоо	Хүүхэд хамгааллын хуулийн талаар иргэдэд мэдээлэл түгээсэн	100 иргэнд мэдээлэл түгээсэн байна	Иргэдийн бүх нийтийн хурлын үеэр хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын талаарх 123 ширхэг боршур хуудсыг тарааж сургуулийн сэтгэл зүйч ерөнхий боловсролын 1,2 дугаар сургуулийн 144 багш ажилтан, 117 эцэг эх асран хамгаалагчдад хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын талаар сургалт мэдээлэл орсон. “Утаанд биш Мөрөөдөлдөө шат” уриатай Сумын хүүхдийн анхдугаар чуулга уулзалт болон Эрсдэлгүй ирээдүй бидний гарт уриатай эцэг эхээ сонсьё өдрүүдээж 400 гаруй сурагч, 200 гаруй эцэг эх асран хамгаалагчид хүүхэд хамгааллын шинэчилсэн найруулгын талаар сургалт мэдээлэл орсон.	01.01-12.30	100

2.	Арга хэмжээ 2 Биеийн тамир спортын тайлан болон бусад холбогдох тайлан мэдээг хугацаанд нь үнэн зөв гаргаж ажиллах	Тайлан мэдээний тоо	Холбогдох тайлан мэдээг хугацаанд нь үнэн зөв гаргаж ажилласан	Сүүлийн хагас жилийн тайлан мэдээг үнэн зөв гаргах	Жилийн эцсийн тайлан мэдээ бусад 10 тайлан, заалны судалгаа, гадна талбайн судалгаа, биеийн тамираар хичээллэгсдийн судалгаа, спортын хэрэглэлийн судалгааг хугацаанд нь үнэн зөв гаргаж холбогдох байгууллагад өгсөн.	01.01-12.30	100
3.	Арга хэмжээ 3 Сумын жендерийн дэд зөвлөлийг байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулан, сургалт нөлөөллийн ажил зохион байгуулах	Жендерийн салбар хороо байгуулагдсан байна	Жендерийн салбар хороо байгуулагдсан	Жендерийн эрх тэгш байдлын талаар 2 сургалт орсон байна	Сумын засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн А/66 тоот захирамжаар сумын Засаг даргаар ахлуулсан 7 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг байгуулсан. Бүсийн эмчилгээ оношилгооны төвөөс дотуур байрны сурагчдад Охидын шивнээ, Хөвгүүдийн бувтнаа сэдэвтэй унтлагын хувцастай уулзалт хийж 39 охин, 56 хөвгүүд оролцов. Насан туршийн суралцахуйн нэгжтэй хамтран суралцагч иргэн арга хэмжээ зохион байгуулж аж ахуйн нэгж албан байгууллагын төлөөлөл 38 иргэн оролцож угийн бичиг хөтлөх ач холбогдол, хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга, жендерийн эрх тэгш байдлын талаарх сургалт мэдээллийг орсон. Жендерт суурилсан хүчирхийллийн эсрэг 16 хоногийн аяны хүрээнд 11 дүгээр сарын 25-ны өдрөөс 12 дугаар сарын 10-ны өдрийн хооронд төлөвлөгөө гарган ажиллаж байна.	01.01-12.30	100

4	Арга хэмжээ 4 Электрон тамхины хор уршгийн талаар сургалт мэдээллийг түгээж урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах	Урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулсан тоо	Сургалт мэдээллийг цахимаар болон танхимаар түгээж ажилласан	Электрон тамхины хор уршгийн талаар цахимаар болон танхимаар 10 аас доошгүй удаа мэдээлэл түгээж ажилласан байна	- “Утаанд биш, Мөрөөдөлдөө шат” уриатай Хужирт сумын хүүхдийн чуулган зохион байгуулагдаж Ерөнхий боловсролын 1,2-р сургуулийн 13-18 насны 400 гаруй сурагч оролцож үзэл бодлоо илэрхийлэв. - "Хүүхдийн төлөө илүү хариуцлагатай, сонор байцгаая" уриатай найман нэрийн хүнсний дэлгүүр, эм бэлдмэлийн худалдаа үйлчилгээний хамтарсан зөвлөгөөнд 18 дэлгүүр, 1 эмийн сангийн эзэд хамрагдаж өөрсдийн хүслээр бага насны хүүхдэд архи согтууруулах ундаа болон, электрон тамхи худалдаалахгүй байх тангараг өргөсөн. 3 дэлгүүр электрон тамхи худалдаалж байснаа зогсоож сумын хэмжээнд электрон тамхи худалдаалахгүй болсон. - Сургуулийн сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, эрүүл мэндийн нийгмийн ажилтан сурагчидтай хамтран аймгийн засаг даргын 2025 оны 01-р сарын 24-ний өдрийн “Хүүхэд, залуучуудыг электрон тамхины хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай” 01 дугаартай албан даалгаврын биелэлтийг хангаж 6 контент видео нийтэлж 2400 хүн үзсэн ба 134 эцэг эх, 661 сурагчид электрон тамхины хор уршгийн талаар сургалт мэдээлэл орсон. - 10 дугаар сарын 28-ны өдөр Зөв дадал эрүүл ирээдүй уриатай сумын Хүүхдээ сонсьё, Эцэг эхээ	01.01-12.30	100
---	---	--	--	--	--	-------------	-----

					сонсьё өдрийг зохион байгуулж 360 гаруй хүүхэд, 200 гаруй эцэг эх оролцов. Тус өдрөөр эрүүл мэндийн нийгмийн ажилтан электрон тамхины хор уршгийн талаар сургалт, цагдаагийн тасгаас насанд хүрээгүй хүн жолоо барихгүй байх талаар анхааруулга мэдээ хүргэн ажилласан. - Цагдаагийн тасагтай хамтран 6-12 дугаар ангийн сурагчдад электрон тамхины хор уршиг, насанд хүрээгүй хүүхэд тээврийн хэрэгсэл жолоодохгүй байх, үе тэнгийн дээрэлхэлтийн талаар сургалт мэдээлэл орсон.		
5	Арга хэмжээ 5 Ажлын байрны дасгал хөдөлгөөний талаар цахим орчинд түгээж хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх уриалга гаргах	Ажлын байрны дасгал хөдөлгөөний талаар иргэд байгууллагуудад уриалга гаргасан байна	-	Цахимаар 10-аас доошгүй удаа ажлын байрны дасгал хөдөлгөөний талаар мэдээлэл түгээж байгууллагуудын н сдортын хамтлагыг идэвхжүүлэх	Хужирт сумын нэгдсэн групп-д ажлын байрны дасгал хөдөлгөөний талаар 6 бичлэг оруулж нийт 1259 хүн үзсэн байна. Мөн 8 байгууллагад спортын хамтлаг ажиллаж тогтмол дасгал хөдөлгөөн хийж хагас жилийн бие бялдрын сорил авсан.	01.01-12.30	100
6	Арга хэмжээ 6 Иргэдийн бие бялдарын түвшийн тогтоох сорил авах	Жилд 2 удаа 400-аас дээш иргэнээс сорил авсан байна	Сорил авсан	400-аас дээш иргэнээс сорил авсан байна	3-64 настай 404 иргэнээс бие бялдрын түвшин тогтоох сорилыг авч cpanel.sport.gov.mn сайтад шивж оруулж байгаа ба 3-5 настай 115, 6-18 настай 136, 19-өөс дээш настай 153 иргэн сорилд хамрагдсан.	01.01-12.30	100
Зорилт 2. “Нийгмийн зорилтот бүлэг хүн ам өрхийн судалгааг гаргах, Жендрийн асуудал, Нийгмийн салбарын мэдээллийн санг шинэчлэх мэргэжил арга зүйгээр хангах, Үндэсний соёлыг хөгжүүлэн иргэдийг соён гэгээрүүлэх, Нийгмийн зорилтот бүлгүүд, хүн ам, өрхийн суурь судалгааг нарийвчлан гаргах							
1.	Арга хэмжээ 1 Үндэсний соёлыг	Угийн бичиг хөтлөлтийн талаар	Аймгийн хэмжээнд	Угийн бичиг хөтлөх арга	Сумын угийн бичиг хөтлөлтийг эрчимжүүлэх “Нэг өрх- Нэг угийн	01.01-12.30	100

	хөгжүүлэн иргэдийг соён гэгээрүүлэх, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх (Угийн бичиг хөтлөх)	иргэдийн мэдлэг мэдээлэл нэмэгдсэн байна	зохион байгуулагдс ан “Нэг өрх- Нэг угийн бичиг” уралдаанд Хужирт сум дэд байр эзэлсэн.	зүйг нэмэгдүүлэх 3- с доошгүй арга хэмжээг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулсан байна	бичиг” уралдааны хүрээнд ажлын хэсэг байгуулж үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулсан. “ Нэг өрх-Нэг угийн бичиг II ” үзэсгэлэнг зохион байгуулан 87 ахмад хамрагдсан. ЗДТГ-ын албан хаагчдад "Угийн бичиг" сургалтыг соёлын төвтэй хамтран зохион байгуулж 13 албан хаагч сургалтад хамрагдсан. Цагаан сар монгол ёс арга хэмжээний хүрээнд 6-12-р ангийн сурагчдад "Угийн бичиг" сургалтыг зохион байгуулж нийт 45 сурагч хамрагдсан. Шинээр 102 өрх угийн бичгээ хөтөлж эхэлсэн. Соёлын төвд “ Угийн бичиг “ танхимыг шинээр байгуулж иргэдэд сурталчлан таниулах үйл ажиллагааг зохион байгуулсан. Аймгийн хэмжээний "Нэг өрх-Нэг угийн бичиг II" арга хэмжээ уралдаанд шилдэг багаар шалгарч цом мөнгөн шагналаар шагнуулсан. Насан туршийн суралцахуйн нэгжтэй хамтран суралцагч иргэн арга хэмжээ зохион байгуулж аж ахуйн нэгж албан байгууллагын төлөөлөл 38 иргэн оролцож угийн бичиг хөтлөх ач холбогдол, хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга, жендерийн эрх тэгш байдлын талаарх сургалт мэдээлэл орсон.		
2.	Арга хэмжээ 2 Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих орон нутгийн зөвлөлийн үйл ажиллагааны хэрэгжилтийг хангаж	Орон нутгийн зөвлөл байгуулагдаж үйл ажиллагаа явагдсан байна	-	Бүтэн жилийн тайлан мэдээг холбогдох байгууллагад хүргүүлэх	Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих орон нутгийн зөвлөлийг байгуулж төлөвлөгөө боловсруулан ажиллаж холбогдох албан байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж энэ оны тайланг холбогдох	01.01- 12.30	100

	тайлан мэдээг хугацаанд нь гаргах				байгууллагад хүргүүлэн ажилласан.		
3.	Арга хэмжээ 3 Тусгай хэрэгцээт иргэдийн судалгааг гаргах	Тусгай хэрэгцээт иргэдийн судалгаа гарч хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн ажил арга хэмжээ 1 ээс доошгүй удаа зохион байгуулагдсан байна	Тусгай хэрэгцээт хүүхдийн судалгааг гаргаж эцэг эхчүүдэд мэдээлэл өгч ажилласан	Тусгай хэрэгцээтэй насанд хүрэгчдийн судалгаа гарч 1 ээс доошгүй арга хэмжээ зохион байгуулсан байна	Тусгай хэрэгцээт хүүхдийн судалгааг шинэчлэн гаргасан ба нийт 29 хүүхэд асаргааны тэтгэмж авч байна. Тусгай хэрэгцээт насанд хүрэгч 186 байгаа бөгөөд суманд хөдөлмөр эрхлэгч 23 иргэн байна. Аймгийн Засаг даргын удирдамжийн дагуу Хөдөлмөр халамжийн газар нийгмийн бодлогын хэлтэс, монголын тэргэнцэртэй иргэдийн холбоо хамтран хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр төрийн болон хувийн хэвшлийн 10 аж ахуйн нэгж байгууллагад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, хуулийн хэрэгжилтэд хяналт, үзлэг зохион байгуулж, хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт, Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн талаарх сургалтыг зохион байгуулж, аж ахуйн нэгж байгууллагын дарга, эрхлэгч, төрийн албан хаагчдыг хамруулан мэдлэг, мэдээлэл олгов.	01.01-12.30	100

Хоёр “Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах” зорилтын хүрээнд

1.	Арга хэмжээ 1 Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол	Төрийн үйлчилгээний албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлэн ажиллах	2025 оны хагас жилийн тайлан мэдээг хугацаанд нь хүргүүлж	Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлуулсан байна. - Шаард	Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлуулсан. Биеийн тамир спорт, Хүний эрхийн төлөв байдлын тайлан болон бусад байгууллагаас ирсэн хугацаатай бичгийн хариу, тайланг хугацаанд	01.01-12.30	100
----	---	--	---	---	--	-------------	-----

	шийдвэрийн хэрэгжилт шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх		ажилласан.	лагатай бусад баримт, тоо мэдээллийг холбогдох байгууллагад хүргүүлэн ажиллах	нь хүргүүлж ажиллаж байна.		
2.	Арга хэмжээ 2 Албан тушаал, мэргэжил, арга зүйн чиглэлийн сургалт, семинарт оролцох, практик туршлагаа нэмэгдүүлэх	Хамрагдсан арга сургалт хэмжээний тоо	Мэргэжил арга зүйн сургалтад хамрагдсан	Холбогдох байгууллагаас зохион явуулж байгаа мэргэжил дээшлүүлэх болон мэргэшүүлэх төрийн албан хаагчийн сургалтад ажил мэргэжлийн чиг үүргийн дагуу хамрагдсан байна	- Хүүхэд хамгаалал ба кейс менежмент сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан. - Аймгийн хүүхдийн чуулганаар Монголын скаутын холбооноос зохион байгуулсан ерөнхий мэдээлэл олгох сургалтад хамрагдан батламж авсан. - Цахимаар surgalt.gov.mn сайтаар Microsoft 365 программын хэрэглээ, Авилгаас ангид төрийн албан хаагч, Дижитал соёл, Тоон гарын үсгийн сургалт, Монгол бичиг анхан болон дунд шатны сургалтуудад хамрагдан сертификат авсан. - Дохионы хэлний сургалтад хамрагдаж сертификат авсан. - Ажлын байрандаа архив албан хэрэг хөтлөлт болон, цахим залилангаас урьдчилан сэргийлэх сургалтад хамрагдсан	01.01-12.30	100
3.	Арга хэмжээ 3 Тайлан мэдээ мэдээллийг хугацаанд нь үнэн зөв гаргах холбогдох байгууллагад хүргүүлэх.	Хугацаа хэтэрсэн тайлан, албан бичгийн тоо \ хугацаа хэтэрсэн шалтгаан\	Хугацаа хэтэрсэн тайлан мэдээ байхгүй	Тайлан мэдээ хугацаатай албан бичгийн хариуг холбогдох газарт хугацаанд нь хүргүүлсэн	33 Хугацаатай албан бичиг тайлан мэдээг хугацаанд нь хүргүүлж ажилласан. Хугацаа хэтэрсэн тайлан мэдээ байхгүй.	01.01-12.30	100

				байна. Хоцорсон албан бичиг, тайлан байхгүй байна			
--	--	--	--	---	--	--	--

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Бие лэлт ийн хувь
1.	Арга хэмжээ 1 Алдарт эхийн одонгийн материал бүрдүүлж холбогдох газарт хүргүүлэх.	Алдарт эхийн одонг ээжүүдэд олгосон байх	2024 онд 27 ээжийн алдарт эхийн одонг гардуулсан	Алдарт эхийн одонгийн материалыг хоцроолгүй бүрдүүлэх	Нийт 25 ээж алдарт эхийн 1,2 дугаар одон авсан. Алдарт эхийн одон гардуулах үйл ажиллагааг 5 дугаар сарын 30-ны өдөр амжилттай зохион байгуулсан.	01.01- 12.30	100
2.	Арга хэмжээ 2 Хүүхдийн баярын арга хэмжээг Соёлын төвтэй хамтран зохион байгуулах	Хүүхдийн баярын арга хэмжээг зохион байгуулсан байна	2024 онд холбогдох байгууллаг тай хамтран зохион байгуулсан	Хүүхдийн баярын арга хэмжээг зохион байгуулсан байна	Хүүхдийн баярын арга хэмжээг соёлын төв, цагдаагийн тасаг, хүүхэд гэр бүлийн нийгмийн ажилтантай хамтран эцэг эхчүүд болон хүүхдүүдийн насны онцлогт тохирсон гар зургийн уралдаан, аз жаргалтай гэр бүл, дугуйн уран жолоодлогын тэмцээн, ээжүүдийн дартсын тэмцээн, open mic арга хэмжээнүүдийг амжилттай зохион байгуулав.	01.01- 12.30	100

3	Арга хэмжээ 3 Хүүхдийн чуулган-2025 зохион байгуулах	Хүүхдийн чуулганыг зохион байгуулсан байна	Хүүхдийн чуулган зохион байгуулагд аагүй	Хүүхдийн чуулган 2025 -ыг холбогдох байгууллагат ай хамтран зохион байгуулсан байна	“Утаанд биш Мөрөөдөлдөө шат” уриатай Хужирт сумын хүүхдийн анхдугаар чуулган 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр болж 400 гаруй сурагч оролцсон ба Сумын хогийн цэгийн асуудал Гэрэлтүүлэг, нохойны асуудал, электрон тамхины хэрэглээ, Сургуулийн автобусны асуудлуудаар асуулт асууж тодорхой хэмжээний хариулт авч мэдээлэлтэй болсон.	01.01- 06.30	100
4.	Арга хэмжээ 4 "Хүүхдийн төлөө илүү хариуцлагатай, сонор байцгаая" уриатай найман нэрийн хүнсний дэлгүүр, эмийн сан, эм бэлдмэлийн худалдаа үйлчилгээний хамтарсан зөвлөгөөн зохион байгуулах	Зөвлөгөөнийг зохион байгуулах	Найман нэрийн хүнсний дэлгүүр, эм бэлдмэлийн худалдаа үйлчилгээн ий хамтарсан зөвлөгөөн болоогүй	Хамтарсан зөвлөгөөн зохион байгуулсан байх	- 4-р сарын 30-ны өдөр "Хүүхдийн төлөө илүү хариуцлагатай, сонор байцгаая" уриатай найман нэрийн хүнсний дэлгүүр, эм бэлдмэлийн худалдаа үйлчилгээний хамтарсан зөвлөгөөнд 18 дэлгүүр, 1 эмийн сангийн эзэд хамрагдаж өөрсдийн хүслээр бага насны хүүхдэд архи согтууруулах ундаа болон, электрон тамхи худалдаалахгүй байх тангараг өргөсөн. 3 дэлгүүр электрон тамхи худалдаалж байснаа зогсоож сумын хэмжээнд электрон тамхи худалдаалахгүй болсон.	01.01- 06.30	100
5	Арга хэмжээ 5 Хүүхдийн тоглоомын талбайн орчны эрсдэлийн үнэлгээ хийх	Холбогдох байгууллагатай хамтран хүүхдийн тоглоомын талбайн орчны эрсдэлийн үнэлгээг хийх	Үнэлгээ хийгдэж байгаагүй	Тоглоомын талбайн эрсдэлийг үнэлэх	5 дугаар сарын 22 ны өдөр сумын эрэн хайх аврах бүлэг, хөдөлмөрийн асуудал хариуцсан мэргэжилтэн, хүүхэд гэр бүлийн нийгмийн ажилтан, эрүүл мэндийн төвийн нийгмийн ажилтантай хамтран суманд ашиглагдаж байгаа 8 хүүхдийн тоглоомын талбайд очиж эрсдэлийг бүртгэж холбогдох удирдлагуудад мэдээлж эрсдэлгүй Өвөрхангай сайтад 9 цэгийн эрсдэлийг оруулснаас 4 цэгийн эрсдэлийг холбогдох байгууллагатай холбогдон шийдвэрлүүлсэн байна.	01.01- 06.30	100

6	Арга хэмжээ 6 Иргэний андгай өргөх ёслолын үйл ажиллагаа зохион байгуулах	Холбогдох байгууллагатай хамтран 16 нас хүрч шинээр иргэний үнэмлэх авч буй хүмүүст иргэний андгай өргөх ёслолын үйл ажиллагаа зохион байгуулах	Жил бүр зохион байгуулагд даг	Иргэний андгай өргөх ёслол зохион байгуулагдс ан байна	11 дүгээр сарын 28-ны өдөр соёлын төвтэй хамтран Иргэний андгай өргөх ёслолыг амжилттай зохион байгуулсан. Нийт 25 иргэн андгай өргөж батламж үнэмлэхээ гардан авлаа. Мөн “Монгол бахархлын өдөр, Тусгаар тогтнол”-ын өдрүүдийг тохиолдуулан илтгэлийн уралдаан зохион байгуулж 6 илтгэгч оролцов.	01.01-12.30	
---	--	---	-------------------------------	--	--	-------------	--

Гурав. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Бие лэлт ийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Арга хэмжээ 1 Ажлын байранд бие даан суралцах, ажлын цагийг үр бүтээлтэй өнгөрөөх, холбогдох хууль тогтоомжийн талаарх мэдлэгээ дээшлүүлэх	1. Нийгмийн салбарын холбогдох хууль тогтоомжийн талаар мэдлэгтэй байх 2. Албан бичиг төлөвлөх чадварыг нэмэгдүүлсэн байх 3. Албан бичгийн найруулга болон зөв бичгийн дүрэм, журамлагдсан үгсийг цээжлэн албан бичигт ашиглан алдаагүй зөв бичих	Зөв бичгийн дүрэм болон албан бичиг хөтлөлтийн зохих мэдлэгтэй	Албан бичиг төлөвлөхөд суралцсан байна	Албан бичгийн найруулгын мэдлэгээ нэмэгдүүлж өдөр тутмын албан хэрэг хөтлөлтөө сайжруулж байна. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг уншиж судалсан.	01.01-12.30	100
2.	Арга хэмжээ 2	1. Хэрэглээний	Компьютер	Цахим пэйж	Байгууллагын цахим хуудаст нийтлэх	01.01-	100

	Ажил, мэргэжлийн чиглэлээр компьютерын мэдлэгээ дээшлүүлж онлайнаар мэдээ, мэдээлэл, сургалтыг шуурхай хүлээн авч боловсруулах чадвар эзэмшинэ	программууд болон бусад төрлийн программуудыг хурдан шуурхай суралцаж өдөр тутамдаа болон сургалтын аргад ашиглах 2. Нэмэлт хэрэглээний программыг эзэмших Компьютерын мэдлэгээ нэмэгдүүлэх /ppt,exel, word, нэмэлт хэрэглээний программууд/	ын хэрэглээний программ ашиглах мэдлэгтэй	хуудас хөтлөх, хөгжүүлэх, мэдээллийг түгээж сурсан байна	мэдээлэл зураг бичлэгээ чанартай засаж бэлтгэн өгч байгаа. Холбогдох хууль тогтоомж, мэдлэг мэдээллийг иргэд унших, бичлэг хэлбэрээр үзэхэд хялбар болгон засаж цахим хуудаст байршуулж түгээж байгаа. Зураг бичлэг засах Canva, Cap cut программуудыг ашиглаж сурсан. Цахимаар сургалтад хамрагдаж хэвшин шаардлагатай сургалтуудад хамрагдсан.	12.30	
3.	Арга хэмжээ 3 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах АЗ-ын сертификат авах сургалтад хамрагдах	Сургалтад хамрагдаж АЗ сертификатыг авсан байна	АЗ-ын сургалтад хамрагдаагүй	АЗ-ын сургалтад хамрагдаж сертификат авсан байна	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах АЗ-ын сертификат авсан. Уужим 2 дугаар багийн төв төв барих ажлын тендерийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороонд нарийн бичгээр ажилласан.	01.01-12.30	100

ТАЙЛАН ГАРГАСАН:

НИЙГМИЙН БОДОЛГЫН
МЭРГЭЖИЛТЭН

..... /Д.ДАВГА /

.....

ТАЙЛАН ХЯНАСАН:

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА

..... /З.ЦЭЦЭГМАА /

.....